

**Улаанбаатар хотын
Цэвэр агаарын санаачлага
төслийн II үе**

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам/ ЕСБХБ

**Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК**

2012-9 сарын 10



Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага төслийн 2-р үе

Гэрээний дугаар: 22384/EBSF2009-09-117/01

Цэвэр агаар сангаас олон нийтийн
хэлэлцүүлэг явуулах ажлын удирдамж
(Албан даалгавар 3.4.14-15)

Огноо: 2012-9 сарын 10

Байгаль орчин,ногоон хөгжлийн яам
ЕСБХБ

БОНХЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
One Exchange Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл:

Өөрчилсөн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
	2012-9-10	Онно ван ден Хювэл	Сузанне, Ганзориг, Пиет де Вилдт		

Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага төслийн 2-р үе

Улаанбаатар хотын гэр хорооллын уламжлалт зууханд чанар муутай түүхий нүүрс түлэх нь ялангуяа өвлийн саруудад хотын агаар бохирдуулагч гол хүчин зүйл болдог. Хотын агаарын чанар нь оршин суугчдын эрүүл мэнд цаашлаад улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Иймд уламжлалт зуухыг утаа бага ялгаруулдаг зуухаар, түүхий нүүрсийг боловсруулсан, нүүрсэн суурьтай, утаа бага ялгаруулдаг, хэмнэлт сайтай түлшээр солих нь тулгамдаад байгаа агаарын бохирдлын асуудлын нэлээд хэсгийг богино хугацаанд шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээний нэг гэж үзэх болсон. Боловсруулсан түлшний найдвартай нийлүүлэлт, түлш зуухыг зөв хослуулах, тэдгээрийг дэмжсэн орчин, стандартуудыг батлан гаргах нь уг арга хэмжээг үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай. Засгийн газраас боловсруулсан түлшний хэрэглээнд шилжих үйл ажиллагааны тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэхийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас (ЕСБХБ) хүссэн юм. ЕСБХБ нь Засгийн газартай хамтран 2008 оны 9-р сараас боловсруулсан түлшний хэрэглээнд шилжих төлөвлөгөөг боловсруулахаар хамтран ажиллаж эхэлсэн. Уг төлөвлөгөөний үндсэн хэсгийг 2009 оны 6-р сард Засгийн газраар батлуулахаар өргөн барьсан. Засгийн газар уг баримт бичгийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийг зарчмын хувьд баталж, 2010 оны 6-р сард Монгол Улсын их хурал Агаарын тухай багц хуулиудыг баталж гаргасаны дараа тус банк төслийн II үеийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэж баримт бичигт заасан гол хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх Зөвлөхүүдийг шалгаруулж авах ажил гүйцэтгэсэн. Зөвлөхүүд нь уг баримт бичгийн холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт хууль эрх зүй, эдийн засаг, техникийн болон чадавхийг бэхжүүлэхэд шаардлагатай бүхий л тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой.

Энэхүү баримт бичгийг дээр нэр заасан төслийн зорилгоор, зөвхөн ашиглах эрх бүхий талуудад зориулан гаргасан болно. Энэхүү баримт бичгийг өөр бусад талууд өөр зорилгоор ашиглаж үл болно.

Энэхүү баримт бичгийг ашиглах эрх бүхий талуудаас бусад этгээдүүд өөр зорилгоор ашигласнаас үүдэн гарсан үр дагавар, бусад талуудаас нийлүүлсэн мэдээллийн алдаа мадаг, орхигдсон зүйлсийн талаар манай тал ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү баримт бичиг нь нууц мэдээлэл агуулсан оюуны өмчийн бүтээл болно. Бидний болон энэ баримтыг бэлтгэсэн талын зөвшөөрөлгүйгээр бусад талуудад үзүүлэхийг хориглоно.

Гарчиг

	Page
Гарчиг	i
Удиртгал	1
1	Олон нийтийн хэлэлцүүлгийн бодлогын орчин 2
1.1	Олон улсын бодлогын орчин _____ 2
1.2	Үндэсний хэмжээний бодлогын орчин _____ 2
2	Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах ажлын удирдамж 4
2.1	Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын шалгуур _____ 4
2.2	Олон нийтийн хэлэлцүүлгийн үргэлжлэх хугацаа _____ 4
2.3	Олон нийтийн хэлэлцүүлгийн хэлбэрүүд _____ 5
2.3.1	Вэб хуудаст суурилсан олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг _____ 5
2.3.2	Дугуй ширээний хэлэлцүүлэг/сургалт семинар/уулзалтууд _____ 5
2.3.3	Судалгаа/санал асуулга _____ 6
2.4	Олон нийтийн хэлэлцүүлгийн төлөвлөгөө _____ 6
2.5	Үр дүнг нийтэд мэдээлэх, нийтлэх _____ 7
2.6	Зохион байгуулалт _____ 7
2.7	Арга хэрэгсэл _____ 8
2.7.1	“Н” хэлбэр _____ 8
2.7.2	“SWOT” дүн шинжилгээ _____ 9
3	Дүгнэлт 11
Зураг	
Зураг 1 Санал асуулгын “Н” хэлбэрийн жишээ	9
Зураг 2“SWOT” матрикс	10
Хавсралт	
Хавсралт 1: Нэмэлт тэмдэглэл	11

Товчилсон үгийн тайлбар

БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ЦАС	Цэвэр агаар сан
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

Оршил

Бодлогын хүрээний шийдвэрийг нийтэд хүргэх, мэдээлэх, ил тод болгоход олон нийтийн хэлэлцүүлэг чухал арга хэрэгсэл болдог. Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд олон нийтийн хэлэлцүүлгийн ач холбогдлыг өндрөөр үнэлж хууль тогтоомж, бодлогын асуудлаа боловсруулахдаа олон нийтийн хэлэлцүүлгийг түлхүү ашигладаг болж байна. Үүний дагуу Монгол улсад ч иргэд, олон нийттэй зөвлөлдөх, хэлэлцүүлэг явуулах нь бодлого, хөтөлбөрийн чухал хэсгийн нэг болоод байгаа билээ. Иймд Цэвэр агаар сан (ЦАС)-гаас олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах энэхүү удирдамжийг боловсруулан гаргаж байна. Удирдамжид Сангаас олон нийтийн хэлэлцүүлгийг хэзээ, хэрхэн, ямар арга хэлбэрээр явуулахыг авч үзлээ. Иргэд, олон нийттэй зөвлөлдөн тэдний санал бодлыг авч ажиллах нь ЦАС-д зорилтот бүлгүүд болон бодит нөхцөл байдлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл, ойлголт олж авахад туслана. Олон нийтийн хэлэлцүүлгийн зорилго нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ЦАС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг дээшлүүлэх, хөтөлбөр, үйл ажиллагаанд хамрагдсан иргэд олон нийттэй хамтран ажилладаг байхад чиглэнэ.

Удиртгал

Улаанбаатар хот болон бусад төв суурин газруудын агаарын бохирдлыг бууруулахад Цэвэр агаар сан (ЦАС) нь үндэсний хэмжээнд хэрэгжиж буй санхүүгийн гол механизм болж байна. Тус Сангийн дэмжлэг, санхүүжилтээр хэрэгжиж байгаа үйл ажиллагааны ихэнхи нь иргэд олон нийт ялангуяа өнөөгийн байдлаар 180,000 өрх амьдардаг гэсэн тооцоо судалгаа гараад байгаа Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдын идэвхитэй оролцоог шаарддаг. Түүнчлэн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний нэлээд хэсэг нь иргэд, оршин суугчдын зан үйл, ерөнхий хандлагыг өөрчлөхийг шаарддаг. Иймд ЦАС-гийн санхүүжилт бүхий үйл ажиллагаа, арга хэмжээнд иргэд, олон нийтийн оролцоог бий болгох, тэдний санал бодлыг тусгадаг байх үүднээс үндсэн гол ажиллагаануудын хүрээнд олон нийтийн санал, хэлэлцүүлгийг зохион байгуулдаг байх хэрэгтэй. Энэхүү удирдамжид ЦАС-гаас зохион байгуулах олон нийтийн хэлэлцүүлэгт баримтлах ерөнхий бодлогын орчинг тодорхойлж, ямар шалгуур, журмын хүрээнд уг үйл ажиллагааг зохион байгуулж болохыг авч үзлээ. Удирдамжийг олон улсын болон Монгол улсын хэмжээнд дагаж мөрдөж байгаа өнөөгийн бодлогын орчин болон олон нийтийн хэлэлцүүлгийн тэргүүн жишээг үндэслэн боловсруулав.

1 Олон нийтийн хэлэлцүүлгийн бодлогын орчин

Олон нийтийн хэлэлцүүлэг нь иргэд олон нийтэд хамаатай, нөлөөлөх аливаа асуудалд тэдний оролцоог бий болгох чиглэлээр явуулж байгаа зохицуулалтын арга хэмжээ юм. Эдгээр үйл ажиллагааны зорилго нь томоохон хэмжээний төсөл хөтөлбөр эсвэл хууль эрх зүй, бодлогын орчны асуудлын үр дүн, ил тод байдал, олон нийтийн оролцоог дээшлүүлэхэд чиглэдэг. Олон нийтийн санал, хэлэлцүүлэгт ихэнхидээ *мэдээлэх буюу мэдээдэх* (хэлэлцэж зөвлөлдөх асуудлыг мэдээлэх), хэлэлцэх (мэдээллийн хоёр талт урсгал ба санал бодлоо солилцох), *оролцуулах* (бодлого эсвэл хууль тогтоомжийн төсөл боловсруулахад холбогдох болон сонирхогч талуудыг оролцуулах) үйл явц орно (ЭЗХАХБ. 2006).

1.1 Олон улсын бодлогын орчин

Байгаль орчны асуудлаар явуулах олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлгийн цар хүрээ, стандартыг тогтоосон олон улсын гол конвенци бол Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ)-ын Европын эдийн засгийн комиссын “**Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тухай конвенци**” (**Аархусын конвенци**) юм. Тус конвенци нь 1998 оны 6 сарын 25-ны өдөр Данийн Аархус хотноо байгуулагдаж, 2001 оны 10 сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр болж мөрдөгдөж байна. 2009 оны 7 сарын байдлаар тус конвенцид 40 улс орон (үндсэндээ Европын болон Төв Азийн орнууд) нэгдэн орсон байна. Конвенцид нэгдэн орсон Европын улс орнууд Аархус конвенцийн үндсэн зарчмыг хууль тогтоомж, шийдвэрт тухайлбал: усны асуудлаар гаргасан тогтоол (Тогтоол шийдвэр 2000/60/ ЕС)-д тусган хэрэгжүүлж эхлээд байна.

Аархусын конвенци нь иргэд олон нийт, төр хоорондын хамтын ажиллагаанд чиглэдэг бөгөөд тухайлбал иргэд олон нийт төрийн байгууллагуудаас мэдээлэл авах эрх, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсэн эрхийг нь сэргээх гэсэн үндсэн зарчмыг баримталдаг. Уг конвенци нь дэлхий нийтийн хэмжээнд бус ч тус конвенцид бүс нутгийн хэмжээнд Европ, Төв Азийн орнууд нэгдэн ороод байна. Иймд уг конвенци Монгол орны хувьд нээлттэй нэгдэн орох боломжтой юм. Засгийн газраас тус конвенцид нэгдэх санал санаачлага гарган олон нийтийн хэлэлцүүлгийг энэ онд зохион байгуулсан билээ. Монгол Улс Аархусын конвенцид нэгдэн орсноор түүний үндсэн зарчмууд нь олон нийтийн хэлэлцүүлэг явуулах талаар төрөөс баримтлах үндсэн чиглэл, удирдамж байх болно.

Аархусын конвенци:

Аархусын конвенцийн үндсэн 3 зарчим:

- (1) Хүн бүр **мэдээлэл авах** /өргөн хүрээтэй ба энгийн төвөггүй байдлаар/ эрхтэй;
- (2) **Иргэд, олон нийт** шийдвэр гаргах явцад **оролцдог байх ёстой**;
- (3) Хууль буюу конвенцийн заалт зөрчигдсэн тохиолдолд **зөрчигдсэн эрхийг сэргээдэг байх ёстой**.

1.2 Үндэсний хэмжээний бодлогын орчин

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газар олон нийтийн хэлэлцүүлгийн хэд хэдэн гол механизмыг үндэсний бүтэц зохион байгуулалтын хүрээнд авч үзсэн. Ялангуяа сүүлийн жилүүдэд батлан гаргасан уул уурхай, байгаль орчны ихэнхи хуулиудад

ЦАС-гийн олон нийтийн хэлэлцүүлэх явуулах ажлын удирдамж

олон нийтийн хэлэлцүүлгийн зарим хэлбэрүүдийг зааж өгсөн байна. Тухайлбал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-ний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг дурьдаж болно. Түүнчлэн саяхнаас Улаанбаатар хотын захиргаа хотын гол чухал асуудлаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулдаг байх санал санаачлагыг гаргаад байгаа билээ. Гэсэн хэдий ч ийм төрлийн үйл ажиллагааг явуулах талаар албан ёсоор тогтоосон механизмууд байхгүй байсаар байна. Агаарын бохирдлын асуудал болон ЦАС-гийн үйл ажиллагаатай холбоотой явуулах олон нийтийн хэлэлцүүлгийн механизм байхгүй байна.

2 Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах ажлын удирдамж

Аархусын конвенцийн хоёр дахь зарчмын дагуу иргэд олон нийт шийдвэр гаргах явцад оролцдог байх ёстой. Үүний тулд холбогдох талууд үндсэн гол асуудлаар шийдвэр гаргах шатанд олон нийтийн хэлэлцүүлэг явуулж тэдний санал бодлыг авдаг байх хэрэгтэй. Түүнчлэн ямар асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн хэлэлцүүлэг явуулдаг байх, хэлэлцүүлэгт олон нийт хэрхэн оролцох зэрэг нь иргэд олон нийтэд тодорхой байж, гарсан үр дүнг нийтэд мэдээлдэг байх хэрэгтэй. Хэлэлцүүлгийн үр дүнгүүд олон нийтэд нээлттэй байлгаж иргэд тэдгээрийг авах нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй.

ЭЗХАХБ-гийн тодорхойлолтонд дурьдсанчлан олон нийтийн хэлэлцүүлэг нь аливаа дүрэм журам, хөтөлбөрийн чанарыг дээшлүүлэхээс гадна тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулдаг. Энэ нь Засгийн газар болон иргэд олон нийтийн аль алины хувьд хэрэгжилтийг хангахад гарах зардлыг бууруулахад туслана. Түүнчлэн олон нийтийн хэлэлцүүлэг нь төр засгийн газар, төрийн байгууллагуудад байгаа мэдээллийг баяжуулж, тэдний шийдвэр гаргах үйл явцад тус дэмжлэг үзүүлдэг (ЭЗХАХБ. 2006).

2.1 Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын шалгуур

Монгол улсын хууль тогтоомжид агаарын бохирдлын асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, зохион байгуулах талаар тусгайлан тогтоосон шалгуурууд байдаггүй ч ЦАС өөрийн шалгуурыг тогтоох хэрэгтэй. Иймд олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэгт дараахи шалгууруудыг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Хэрэв тухайн үйл ажиллагаа нь 20,000 ба түүнээс дээш тооны ашиг хүртэгчид болон иргэдийг хамруулсан бол,
- Хэрэв тухайн төсөл хөтөлбөрүүд нь 250 сая төгрөгөөс дээш төсөвтэй бол,
- Шинэ төрлийн зуух, түлш болон оршин суугчид, өрхүүдийн амьдралын нөхцөлд нөлөөлөх бусад зүйлийг нэвтрүүлж байгаа бол,
- Хэрэв иргэд олон нийтийн зүгээс ЦАС-д уриалсан буюу олон нийтэд жишээ загвар болгон үзүүлэх, танилцуулах ажлыг зохион байгуулах болон олон нийтэд хүргэхийг зорьж байгаа бол,
- Хэрэв Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, ЦАС-гийн Удирдах зөвлөл, Үндэсний хороо буюу ЦАС-гийн Гүйцэтгэх захирал шаардлагатай гэж үзсэн тохиолдолд,
- Шинэ хууль тогтоомж, үндэсний хэмжээний хөтөлбөр буюу стратеги боловсруулах бол олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлгийг зохион байгуулдаг байх хэрэгтэй.

2.2 Олон нийтийн хэлэлцүүлгийн үргэлжлэх хугацаа

Олон нийтийн дунд явуулах санал асуулга, хэлэлцүүлгийн үргэлжлэх хугацааг тодорхой тогтоосон байх хэрэгтэй. Ерөнхийдөө үргэлжлэх хугацаа нь 3 сараас хэтрэхгүй байх нь зүйтэй. Зөвхөн маш онцгой тохиолдолд уг заасан хугацаанаас хэтэрч болно. Тухайлбал: Засгийн газраас өвлийн улиралд хэрэгжүүлж байгаа боловсруулсан түлшний хөтөлбөрийн талаар тодорхой газруудын оршин суугч, хэрэглэгчдийн санал дүгнэлтийг авах хэрэгтэй бол хугацааг уртаар тогтоож болох юм. Олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлгийг сонгуулийн үеэр зохион байгуулдаггүй байх хэрэгтэй.

2.3 Олон нийтийн хэлэлцүүлгийн хэлбэрүүд

Олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг явуулах төрөл бүрийн арга хэлбэрүүд байдаг. Хэлэлцүүлэгт хэд хэдэн арга, хэлбэрийг хослуулан ашиглаж болно. Сангаас зохион байгуулах олон нийтийн хэлэлцүүлэгт дараахи арга хэлбэрүүдийг ашиглаж болно. Үүнд:

1. Вэб хуудаст суурилсан олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг
2. Дугуй ширээний хэлэлцүүлэг/сургалт семинар/уулзалтууд
3. Судалгаа, санал асуулга.

2.3.1 Вэб хуудаст суурилсан олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг

Интернет, вэб хуудсаар дамжуулж явуулах олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг нь өргөн хүрээг хамрахаас гадна ил тод байдлыг бий болгох давуу талтай. ЦАС-гийн вэб хуудсыг ашиглан олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг явуулах нь зардал багатайн дээр олон нийтэд уг вэб хуудаст орж мэдээлэл авдаг, ашигладаг болох боломж олгоно. Гэхдээ энд зөвхөн Сангийн вэб хуудсаар хязгаарлах бус олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлгийн тусгай хэсгийг бий болгоод байгаа Ерөнхийлөгчийн тамгийн газрын вэб хуудсаар дамжуулан уг хэлэлцүүлгийг явуулж болно. Түүнээс гадна нийгэмд өргөн хүрээгээр ашиглагдаг Facebook, Twitter зэргийг тодорхой асуудлын хүрээнд ашиглаж болох юм. Вэб хуудсаар дамжуулж явуулах санал асуулга, хэлэлцүүлэгт үндсэн гол асуудлаар 1-2 асуулт тусгайлан бэлтгэн вэб хуудснаа байрлуулан иргэд олон нийтээс хариулт, санал авах, түүнчлэн бодлогын тодорхой баримт бичгүүдийг вэб хуудаст байрлуулан иргэд олон нийттэй санал бодлоо хуваалцдаг байна. Энэ хэлбэрийн тухайд анхаарах зүйл бол хугацаа болон оролцогчдын өгөх санал нь маш тодорхой байх хэрэгтэй. Түүнчлэн оролцогч хүмүүс болон олон нийтийн өгч буй саналын үр дүн нь тухайн вэб хуудаснаа тодорхой харагддаг байх нь чухал. Харин энэ хэлбэрийн хувьд гарч болох сул тал бол гэр хорооллын оршин суугчид ялангуяа амьдралын түвшин доогуур өрхүүд интернет ашиглах боломж багатай тул тэдэнд уг ажиллагаанд оролцох боломжийг багасгадаг байна. Энэ нь уг хэлэлцүүлэгт зөвхөн хүн амын тодорхой хэсэг тухайлбал амьдралын түвшин боломжийн хэсэг хүмүүс хамрагдаж саналаа өгөх болно гэсэн үг юм.

2.3.2 Дугуй ширээний хэлэлцүүлэг/сургалт семинар/уулзалтууд

Уулзалт ярилцлага буюу дугуй ширээний хэлэлцүүлэг зохион байгуулах нь холбогдох асуудлаар мэргэжилтэн, экспертүүдийг оролцуулах давуу талтай. Ийм уулзалт, хэлэлцүүлгийг хямд төсөр зардлаар зохион байгуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг урьж оролцуулдаг байх нь чухал. Түүнчлэн уулзалт, хэлэлцүүлэгт төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийг урьж оролцуулах боломжтой. Гэр хорооллын болон хөдөө орон нутгийн оршин суугчдад интернет ашиглах боломж хязгаарлагдмал байдаг болохоор телевиз, радиог түлхүү ашиглах хэрэгтэй. Телевиз, радиогийн нэвтрүүлгийн төлбөр тодорхой хязгаартай. Үндэсний хэмжээний мэдээллийн хэрэгслийг ашиглах нь асуудлыг өөр бусад газрууд, аймгуудын оршин суугчдад хүргэх боломж олгоно. Үндэсний хэмжээний хөтөлбөр нь хэлэлцэж буй асуудлуудаас гадна тэдгээртэй холбоотой бусад асуудлуудыг тухайлбал: агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, эрсдэлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэснээр агаарын бохирдлыг бууруулахад иргэд, оршин суугчдын зан үйл, хандлагыг өөрчлөхөд чухал үүрэгтэй байж, энэ нь агаарын бохирдлыг бууруулахад чухал түлхэц үзүүлэх болно. Дугуй ширээний ярилцлага, уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулахдаа анхаарах зүйл бол зорилго, зорилт нь тодорхой байх энэ нь тэдгээрээс гарах үр дүн, бодлогын зөвлөмжүүдэд тустай.

2.3.3 Судалгаа/санал асуулга

Судалгаа ялангуяа санал асуулга бүхий судалгаа нь нэлээд цаг хугацаа, зардал шаардсан ажил боловч олон талын мэдээ, мэдээлэл цуглуулах, олон нийтийн санал дүгнэлтийг нарийвчлан авч үзэхэд хамгийн оновчтой арга байдаг. Аливаа судалгааг сайтар боловсруулж гаргадаг байх хэрэгтэй. Судалгаа авахдаа тухайн асуудалд хамаатай хүмүүсийг хамруулж, тэдний өгсөн санал хариултуудыг нэгтгэх ажил хийгдэнэ. Судалгаа санал асуулгыг тухайлбал зарим төрлийн зуух, боловсруулсан түлш нэвтрүүлэх зэрэг иргэд оршин суугчдын амьдралын нөхцөлд нөлөөлөх тодорхой асуудлаар эсвэл мэдээлэл сурталчилгааны кампанит ажлын үр өгөөжийг тогтооход ашиглах хэрэгтэй. Олон нийтийн хэлэлцүүлгийн хүрээнд зохион байгуулж байгаа судалгаа нь төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны зорилтот бүлэг ба ашиг хүртэгчдийн ойлголт, санал дүгнэлтийг авахад туслана. Энэ аргын сул тал бичиг үсэггүй ба тодорхой хэмжээнд хязгаарлагдмал хүмүүсийн дунд явуулахад, мөн чанарын талаар мэдээлэл олж авахад хүндрэл гарч болох талтай. Явуулах судалгаа бүрийн хувьд тоо ба чанарын судалгаа, мэдээллийг ямар хэмжээнд олж авах боломжтойг тогтоосон байх хэрэгтэй.

Биечлэн уулзаж ярилцахын оронд утсаар ярилцах хэлбэр байж болох бөгөөд энэ аргын давуу тал нь санал асуулга, хэлэлцүүлэгт ихэнхидээ оролцож чаддаггүй хүмүүстэй ярилцах, тэдний санал бодлыг авах боломж олгоно.

Олон нийтийн хэлэлцүүлгийн аль ч арга хэлбэрт дараахи **зарчмуудыг** мөрддөг байна. Үүнд:

- Холбогдох бүх бүлэг, талуудыг хамруулах оролцооны аргуудыг сонгох
- Амралтын үеэр үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулахаас зайлхийх
- Этгээд үг хэллэг болон мэргэжлийн үг хэллэг хэрэглэхээс зайлсхийх
- Төлөөлөл болгон оролцох бүлгүүд (жишээ нь: өндөр настай хүмүүс, өрх толгойлсон эмэгтэйчүүд гм)- ийн хэрэгцээг сайтар анхаарсан байх хэрэгтэй.

2.4 Олон нийтийн хэлэлцүүлгийн төлөвлөгөө

Олон нийтийн хэлэлцүүлэг бүрийг уг үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, оролцогч нь хэн байх, тэдний үүрэг хариуцлага юу болохыг тодорхой зааж өгсөн төлөвлөгөөнд үндэслэн явуулдаг байх хэрэгтэй. Түүнчлэн тухайн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг урьдчилан тооцож гаргасан байна. Олон нийтийн хэлэлцүүлгийн төлөвлөгөөнд дараахи зүйлийг оруулсан байна. Үүнд:

1. Зорилго
2. Хугацаа
3. Оролцогчдын дүн шинжилгээ
4. Аргачлал
5. Зөвлөж, хэлэлцэх асуудлууд
6. Үүрэг хариуцлага
7. Төсөв

2.5 Үр дүнг нийтэд мэдээлэх, нийтлэх

Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг ЦАС-гийн болон бусад холбогдох вэб хуудаснаа тавьж олон нийтэд мэдээлдэг байх хэрэгтэй. Иймд вэб хуудаст олон нийтийн санал авах, тэдгээрийн үр дүнг танилцуулах тусгай хэсэгтэй байх хэрэгтэй. Хэлэлцүүлэг явуулж дууссанаас хойш нэг сарын дотор түүний үр дүнг, тухайн үр дүнд үндэслэн гаргасан шийдвэрийн хамт олон нийтэд мэдээлдэг байна. Энэ нь олон нийтэд мэдээлэл авах боломж олгоно.

Олон нийтийн хэлэлцүүлгийн тайланд дараахи зүйлийг тусгасан байна. Үүнд:

1. Үр дүнгийн тухай товч танилцуулга
2. Үйл явц үүнд дараахи зүйлийг оруулах:
 - Зөвлөлдөх үйл ажиллагааны зорилго
 - Хугацаа
 - Оролцогчид, тэдгээрийн тоо
 - Оролцох арга (санал дүгнэлтийг хэрхэн авах, цуглуулах ба олон нийттэй хэрхэн зөвлөх, хэлэлцэх)
 - Тавьсан зорилго хэрхэн биелэгдсэн тухай оруулсан байна.
3. Оролцогчдын зүгээс дэвшүүлж тавьсан асуудлуудад дүн шинжилгээ хийх, энэ нь дараахи асуудлыг авч үзэхэд туслана. Үүнд:
 - Оролцогч бүлгүүдээс ямар асуудлыг дэвшүүлэн тавьсан
 - Асуудал бүрийг хэрхэн авч үзэх
 - Санал авснаар ямар нэг өөрчлөлт хийгдэх эсэхэд дүн шинжилгээ хийнэ.

ЦАС-гийн Удирдах зөвлөл нь тайланг бүрэн хэмжээгээр олон нийтэд танилцуулах эсэхийг шийдэх ч гарсан үр дүнгүүдийн мөн чанар, арга хэмжээ нь хангалттай хэмжээнд, үнэн зөв явагдсан эсэхийг баталгаажуулна.

2.6 Зохион байгуулалт

Олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулахад хийгдэх эхний алхам бол зорилгоо тодорхойлно. Түүний дараа тухайн ажлыг хариуцан ажиллах хүн /task leader/-ийг томилно. Тухайн томилогдсон хүн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагааг зохион байгуулах, үйл ажиллагааны тайлан боловсруулах үүрэг хүлээнэ. Төлөвлөгөөнд хэлэлцүүлгийг ямар хэлбэрээр явуулах, түүний хугацаа, зохион байгуулахад оролцох багийн гишүүд, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлж, төсвийг тооцон гаргасан байна.

Уг үйл ажиллагааг зохион байгуулж дууссаны дараа тайланг бичиж ЦАС-гийн Гүйцэтгэх захиралд өгнө. Тайланд Сангийн болон бусад холбогдох вэб хуудаст байрлуулах мэдээллийн товчоог оруулсан байна.

2.7 Арга хэрэгсэл

Олон нийтийн хэлэлцүүлэгт ашиглаж болох олон арга хэрэгсэл байдаг. ЦАС болон түүний хамтрагч байгууллагууд иргэд олон нийттэй зөвлөлдөх ажиллагааг зохион байгуулах, явуулахад олон арга хэрэгслээс ашиглаж болно. Ашиглаж болох зарим нэг арга хэрэгслээс энд жишээ болгон оруулав.

2.7.1 “Н” хэлбэр


Энэ нь орон нутгийн түвшинд иргэд олон нийтийн хэлэлцүүлэг явуулахад ашиглаж болох хамгийн энгийн арга юм. Үүнийг ихэнхидээ сургалт, семинаруудад үнэлгээ өгөхөд ашигладаг ч тодорхой бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний талаар иргэд олон нийтийн санал авахад ашиглаж болно.

Санал асуулгын “Н”- хэлбэрийг ашиглахдаа оролцогчдод нэг том цаас, үзэг, хангалтай хэмжээний өнгийн цаас өгнө. Том цаасан дээр “Н” зурна. Хэлэлцэж буй асуултыг цаасны дээд хэсэгт бичнэ. “Н”-ийн хэвтээ зураасны зүүн өнцөгт 0-ыг түүний дагуу нөгөө/баруун талд 10-г бичнэ. Оролцогч бүлэг бүрийн төлөөлөл өөр өөрсдийн оноог тавина. Өгсөн оноо бүрт жишээ нь: “тэд яагаад дээд оноо ба 10-г өгөөгүй вэ?” гэсэн асуултын дор өнгийн цаасан дээр бичсэн саналыг “Н”-ийн зүүн талын зайд байрлуулна. Үүнтэй адил цаасны баруун талд өгсөн эерэг асуултын дор өгсөн оноо бүрийн саналыг байрлуулна. Түүний дараа оролцогчид өөр өөрсдийн өгсөн сөрөг, эерэг хариулыг уншиж танилцуулж өөрийн бүлгийн оноог гаргана.

Ийм хэлбэрийн санал асуулга нь оролцогчдыг хэлэлцэж буй асуудалд бүрэн чиглүүлж тодорхой, идэвхитэй байх, тухайн өгсөн саналынхаа хүрээнд цаашид юу хийх шаардлагатай байгаа талаар санал бодлоо хуваалцах боломж олгоно. Түүнчлэн хэлэлцүүлгийн энэ хэлбэр нь оролцогч хүмүүсийн хувьд өөр нэг идэвхижүүлэгчийн оролцоогүйгээр өөрсдийн саналаа дүгнэх, үр дүнг харах боломж олгоно. Түүнээс гадна хэлэлцүүлгээс гарсан үр дүнг ямар нэг нэмэлт тайлбар, тэмдэглэгээгүйгээр тайланд шууд оруулах боломжтой байна. Санал асуулгын “Н” хэлбэрийн жишээг **Зураг 1** –т оруулав.

Зураг 1 Санал асуулгын “Н” хэлбэрийн жишээ

Асуултыг энд оруулах



2.7.2 “SWOT” дүн шинжилгээ

Өөр нэг арга бол “SWOT” дүн шинжилгээ (“SWOT” матрикс) юм. Уг дүн шинжилгээг ихэнхидээ стратегийн төлөвлөлт хийх эсвэл байгууллага буюу тодорхой бүтцийн хүрээнд тэдний давуу ба сул талуудыг судлан цаашид сайжруулах талаар ямар арга хэмжээ авах хэрэгцээг тодорхойлоход ашигладаг. Иймд энэ аргыг олон нийтийн бүлэг, орон нутгийн засаг захиргаа, боловсруулсан түлш нийлүүлэгчдийн бизнес зэрэг тодорхой үйл ажиллагааны хүрээнд асуудал хэлэлцэх, зөвлөлдөхөд ашиглахад тохиромжтой. Түүнчлэн энэ аргыг бодлогын асуудал хэлэлцэхэд ашигладаг.

“SWOT” дүн шинжилгээнд:

- **Давуу тал:** байгууллага буюу төслийн багийн давуу талууд, тэдгээрийн онцлог
- **Сул тал** (буюу дутагдал): байгууллага буюу багийн сул талууд тэдгээрийн онцлог
- **Боломж:** гүйцэтгэл (жишээ нь: агаарын бохирдлыг бууруулах)-ийг сайжруулахад нөлөөлөх гадаад боломж
- **Аюул:** бизнес буюу төслийн үйл ажиллагаанд асуудал үүсгэж болох гадаад хүчин зүйлс /элементүүд/-ийг тус тус тодорхойлдог.

Энэ дүн шинжилгээг байгууллагын буюу төслийн давуу ба сул талууд тэдгээрийн орчинг тодорхойлоход ашиглаж болно. Загвар жишээг Зураг 2-т оруулав.

Зураг 2“SWOT” матрикс

	Эерэг	Сөрөг
Дотоод хүчин зүйл	ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
Гадаад хүчин зүйл	БОЛОМЖ	АЮУЛ

3 Дүгнэлт

Байгаль орчны асуудлаар явуулах олон нийтийн хэлэлцүүлэгт баримтлах үндсэн ойлголт, концепцийг олон улсын конвенци болон Монгол улсын бодлогын орчинд тогтоож өгсөн байна. Сүүлийн үед Монгол орны хот суурин газруудын агаарын бохирдол зэрэг асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах шаардлага нэлээд гарч байна. Гэхдээ олон нийтийн хэлэлцүүлгийг хэрхэн явуулах талаар тодорхой удирдамж чиглэл байхгүй байсаар байна. Иймд энэхүү удирдамжийг гарган, ЦАС-гаас санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах ажлыг хэлбэршүүлэхийг зорилоо. Энэхүү удирдамж нь ЦАС-гийн ажилтнууд болон хамтрагч байгууллагуудын хувьд олон нийтийн хэлэлцүүлэг явуулахад тодорхой чиглэл өгч, олон нийтийн дунд явуулах санал асуулга, хэлэлцүүлгийн үр дүнг дээшлүүлэхэд туслах болно.

Хавсралт 1: Нэмэлт тэмдэглэл

Гэрээний нэр:	Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага – II үе – Төслийн хяналт удирдлага
Тайлангийн нэр:	Цэвэр агаарын сангаас олон нийтийн хэлэлцүүлэг явуулах ажлын удирдамж
Захиалагч	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
Захиалагчийн гэрээний дугаар	C22384/EBSF-2009-09-117/01
Захиалагчийн холбогдох мэдээлэл:	БОНХЯ, Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газар Засгийн газрын байр II Нэгдсэн Үндэстний гудамж 5/2 Улаанбаатар хот-210646 Монгол улс
Зөвлөх	Евроконсалт Мотт Макдоналд Амстердамсеев 15, Арнхем Шуудангийн хайрцаг 441 6800 АК Арнхем Нидерланд улс Утас: +31 (0) 26 357 7111, Факс: +31 (0) 26 357 7577 И-мэйл: euroconsult@mottmac.nl , вeб хуудас: www.euroconsult.nl
Гэрээний менежер/ Төслийн захирал	Каролин ла Чапелл И-мэйл: caroline.lachapelle@mottmac.nl
Багийн ахлагч/ Төслийн менежер	Пиет де Вилдт И-мэйл: piet.wildt@mottmac.nl